“ЖИРЭМСНИЙ ХЯНАЛТЫН ЧАНАРЫГ ҮНЭЛЭХ НЬ”
СУДАЛГААНЫ ТӨСӨЛТ АЖИЛ

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Улаанбаатар хот

2023 он

“Жирэмсний хяналтын чанарын үнэлгээ” судалгааны төслийн ажил

Судалгааны ажил гүйцэтгэгч:

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

Ажлын хэсгийн дарга:

Ш.Алтантуяа, ЭХЭМҮТ-ийн ерөнхий захирал, АУ-ны доктор

Ажлын хэсгийн дэд дарга:

Х.Цолмон, ЭХЭМҮТ-ийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал, АУ-ны доктор

Ажлын хэсгийн зөвлөх:

С.Хишгээ, ЭХЭМҮТ-ийн зөвлөх эмч, АУ-ны магистр

Д.Энхмаа, ЭХЭМҮТ-ын ЭШСГХ хариуцсан дэд захирал, АУ-ны доктор

Ерөнхий зохицуулагч:

Б.Чинзориг, ЭХЭМҮТ-ийн их эмч, АУ-ны магистр

Гишүүд:

1. Ц.Отгонцэцэг, ТСА-ны их эмч, АУ-ны магистр
2. Я.Хишигсүрэн, АУ-ны магистр
3. Б.Тэмүүлэн, НҮ зохицуулагч
4. А.Мөнхзул, АУ-ны магистр
5. З.Цолмонгарав, АУ-ны магистр
6. Б.Батжаргал, АУ-ны магистр
7. Б.Наранчимэг, АУ-ны магистр
8. Г.Саранцацрал, АУ-ны магистр
9. Б.Базарсүрэн, АУ-ны магистр
10. Ц.Уянга, АУ-ны магистр
11. Д.Балцэцэг, Эх барих эмэгтэйчүүдийн эмч
12. С.Тунгалаг, Эх барих эмэгтэйчүүдийн эмч
13. Л.Мөнхдэлгэр, Эх барих эмэгтэйчүүдийн эмч
14. А.Алтанцэцэг, Эх барих эмэгтэйчүүдийн эмч

15. М.Мөнхцацрал, Эх барих эмэгтэйчүүдийн эмч
16. Л.Номинэрдэнэ, Эх барих эмэгтэйчүүдийн эмч
17. Э.Насантогтох, ЭША
18. Б.Балжинням, ЭША
19. Э.Оюунханд, ЭША

Судалгааны төслийн гүйцэтгэх хугацаа:

2023 оны 2-4-р улирал

Судалгааны төслийн санхүүжүүлэгч:

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Судалгааны төслийн зардал:

Судалгааны нийт зардал – 26.683.700 төгрөг.

Төслийг хамтран хэрэгжүүлэх байгууллага

- ЭХЭМҮТ
- Сонгогдсон байгууллага

Нэр томьёоны товчлол

АУ	Анагаах ухаан
АНЭ	Аймгийн нэгдсэн эмнэлэг
ДНЭ	Дүүргийн нэгдсэн эмнэлэг
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
МУ	Монгол Улс
НҮ	Нөхөн үржихүй
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СЭМТ	Сумын эрүүл мэндийн төв
ТСА	Тандалт судалгааны алба
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
УИХ	Улсын их хурал
ҮҮН	Үйлчилгээ үзүүлэгч нэгж
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЭБЭЭ	Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг
ЭМ	Эрүүл мэнд
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЭМД	Эрүүл мэндий даатгал
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭНЭҮТ	Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв
ЭХЭМҮТ	Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв
ЭЭХ	Эхийн эндэгдлийн харьцаа
ЭША	Эрдэм шинжилгээний алба

АГУУЛГА

Нэр томьёоны товчлол 4

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ 6

2.1. Судалгааны зорилго 8

2.2. Судалгааны зорилт 8

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ 9

3.1. Судалгааны загвар 9

3.2. Судалгааны түүвэр 9

3.3. Судалгааны хэрэглэгдэхүүн 13

3.4. Судалгааны зохион байгуулалт: 14

3.5. Судалгааны статистик боловсруулалт 14

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН 14

4.1. Жирэмсний хяналтын чанарын судалгаанд хамрагдсан ҮҮН-ийн ерөнхий мэдээлэл 14

4.2. ҮҮН-ийн жирэмсний хяналтын чанарыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шатлалаар харьцуулсан үр дүн 17

4.3. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүс нутгийн ҮҮН-ийн жирэмсний хяналтын чанарыг үнэлсэн үр дүн 21

4.4. Жирэмсний хяналтын чанарт ҮҮН-ийн эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний үзүүлэх нөлөөллийг тооцсон үр дүн 27

4.5. Жирэмсний хяналтын чанарын үнэлгээ 32

ТАВДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ 37

Хавсралт 1. ТООН СУДАЛГААНЫ АСУУМЖ 39

Хавсралт 2. ЧАНАРЫН СУДАЛГААНЫ АСУУМЖ 63

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн Газар, Эрүүл Мэндийн Яамнаас эх, хүүхдийн эрүүл мэндэд чиглэсэн олон талт арга хэмжээ авч, хэрэгжүүлсний үрээр эх, хүүхдийн эндэгдэл буурсан. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 тоот тушаалаар ”Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. Уг арга хэмжээний хэрэгжилтийн явцад (2021-2024 онд) эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрх зүйн орчинг сайжруулах, нийгэм, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийг бүрдүүлэх үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, судалгаа хийж, нотолгоонд суурилсан тусламж үзүүлэх, эрсдлийг бууруулах замаар эрүүл мэндийн хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээг бүх нийтэд тэгш хүргэснээр эх, хүүхдийн эндэгдлийг тогтвортой бууруулах юм[1].

Монгол улсад хийгдсэн 5 дахь удаагийн “Эх яагаад эндэв? Итгэмжит лавлагаа” судалгааны дүнгээс харахад 2016-2019 онд 308273 амьд төрөлт, 97 эхийн эндэгдэл бүртгэгдэж, эхийн эндэгдлийн харьцаа (ЭЭХ) 31.5 (95% CI 12.9-49.9) байгаа ба 2016 онд эхийн эндэгдлийн харьцаа 48.6 байсан бол жил тутам тогтвортой буурсаар 2019 онд 23.0 болсон байна[2]. Эх жирэмсэн үедээ эмчийн хяналтад байснаар үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдаж, өвчин илэрсэн тохиолдолд эмчлүүлэх, үүсч болзошгүй эрсдэл хүндрэлээс сэргийлэх, ургийн бойжилтын байдлыг хянуулан, эрүүл мэндийн зөвлөгөө авах, амаржихад бэлтгэх, амаржсаны дараа нярайн асаргаа, сувилгаа, дараагийн жирэмслэлт, гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэлтэй болно. Эхчүүд жирэмсний хяналтад эрт орсноор эх, хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Монгол Улсын жирэмсний хяналтын журамд хэвийн явцтай жирэмсэн эмэгтэйг 6 удаа, өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг 8 удаа үзүүлэхийг зөвлөдөг.[3] Жирэмсний хяналтын чанар эхийн эндэгдэлд гол нөлөө үзүүлдэг эрүүл мэндийн үзүүлэлт бөгөөд жирэмсний хяналтыг сайн сургагдсан эрүүл мэндийн ажилтан чанартай үзүүлж чадвал эхийн эндэгдлийг 63.2%

[1]Эрүүл мэндийн үзүүлэлт, 2021, Эрүүл мэндийн хөгжлийн төв, хуудас 43
[2]Эх яагаад эндэв? 2016-2019 Итгэмжит лавлагаа судалгаа, 2019 он
[3]ЭМС-ын 2014 оны 338 тоот тушаал (Жирэмсэн болон төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний журам)

бууруулах боломжтой.[4] Жирэмсэн эмэгтэй жирэмсний бүхий л хугацаанд мэргэшсэн эрүүл мэндийн мэргэжилтний тусламж= үйлчилгээг авах эрхтэй. Монгол Улсад 2016-2019 онд эндсэн (n=97) эхийн 83.5% (n=81) жирэмсний хяналтад орсон, 13.4% (n=13) ороогүй, 3.1% (n=3) хяналтад орох боломжгүй, мэдээлэлгүй (умайн гадуурх жирэмсэн) байв. Жирэмсний хяналтад орсон (n=81) эхийн 82.7% (n=67) эрт, 17.3% (n=14) хожуу үед хяналтад хамрагдсан ба жирэмсний хожуу үед хяналтад орсон эхийн эзлэх хувь өсөх хандлагатай байна[5]. ДЭМБ-аас 2016 онд гаргасан “Жирэмсэн үеийн нөхцлийг сайжруулахад чиглэсэн эрүүл мэндийн тусламжийн зөвлөмж“[6] удирдамжийг үндэслэл болгон Монгол Улсад “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээний журам”-ыг Эрүүл мэндийн сайдын 2020 оны 06 сарын 04-ний өдрийн 318 тоот тушаалаар батлан гаргасан. Уг журмыг жирэмсэн, төрөх, төрсний дараах үед тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрийн болон хувийн хэвшлийн бүх эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хэрэгжүүлэн ажилладаг. Энэхүү журам хэрэгжсэнээр жирэмсэн, төрөх, төрсний дараах үед эх, ураг, нярайн эрүүл мэндэд тулгарч буй эрсдэлийг эрт илрүүлэх, тандах, хүндрэлээс сэргийлэх, эмчлэх, эсэн мэнд амаржуулах, нотолгоонд суурилсан цогц тусламжийг хугацаа алдалгүй үзүүлэх зэрэг олон үйл ажиллагаа зохицуулагдсаар байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтод “Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин буурсан байна” гэж заасан. Уг хөтөлбөрийн бодлогод “Нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоо бүрдүүлэх” хэмээн тусгагдсан. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд өөрчлөлт ороод байна[7].

[4]Potential impact of midwives in preventing and reducing maternal and neonatal mortality and stillbirths: aLives Saved Tool modelling study, Andrea Nove,Ingrid K Friberg et all, lancet Glob Health, 2021; 9:e24-32

[5]Эх яагаад эндэв? 2016-2019 Итгэмжит лавлагаа судалгаа, Жирэмсний хяналт, хуудас 28

[6]ДЭМБ, Жирэмсэн үеийн нөхцлийг сайжруулахад чиглэсэн эрүүл мэндийн тусламжийн зөвлөмж

[7]Алсын хараа – 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

Монгол Улсын Засгийн Газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 сарын 09-ний өдрийн А/760 тоот тушаалаар батлагдсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөний зорилт 3-т “Жирэмсний хяналтын тогтолцоонд үнэлгээ хийх”-ээр тусгагдсан байна.

2021 оны байдлаар улсын хэмжээнд 65760 жирэмсэн эмэгтэй хяналтад хамрагдсан бөгөөд 90.6% нь жирэмсний эхний 3 сартайд, 8.7% нь 4-6 сартайд, 0.7% нь хожуу буюу 7 ба түүнээс дээш сартайдаа хяналтад хамрагджээ. Жирэмсний эрт үеийн хяналтыг хот, хөдөөгөөр авч үзвэл хотод жирэмсэн эмэгтэйчүүдийн 90.0%, хөдөө орон нутагт 91.2% нь жирэмсний эрт үедээ хяналтад хамрагдсан ба өмнөх онтой харьцуулахад хотод 0.7% хувиар, хөдөө орон нутагт 0.7% хувиар өссөн байна[8]. Монгол Улсын нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны дүнгээс үзэхэд 2018 онд жирэмсний хяналтын хугацаанд ЭМ-ын мэргэжлийн ажилтанд 1 удаа үзүүлэх нь 98.2%:97.2%, 4 удаа үзүүлэх 92.1%:88.5%, 6 удаа үзүүлэх нь 82.7%:72.7% байсан ба хот хөдөөд ялгаа байгаагүй байна[9]. 2019 онд төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг бууруулахаар ЭМС-ын А/614 тоот тушаал батлагдсан. Сүүлийн 2 жилд төрөлхийн тэмбүүгийн тохиолдол буурч байна.

2.1. Судалгааны зорилго

Үндэсний хэмжээнд жирэмсэн болон төрсний дараах үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хэрэгжилтийг үнэлэх, цаашдын хэрэгцээг тодорхойлж, дүгнэлт, зөвлөмж гаргаснаар эхийн ноцтой хүндрэл болон эндэгдэл, перинатал эндэгдлийг бууруулах, сэргийлэхэд оршино.

2.2. Судалгааны зорилт

1. Жирэмсний хяналтын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэх
2. Жирэмсний хяналтын тусламж үйлчилгээний удирдамж, зааврын хэрэгжилтийг үнэлэх
3. Жирэмсний хяналтын тусламж үйлчилгээг сайжруулах хэрэгцээг тогтоож, зөвлөмж гаргах

[8]Эрүүл мэндийн үзүүлэлт, 2021, Эрүүл мэндийн хөгжлийн төв, хуудас 43
[9] Нөхцөл байдлын үнэлгээ, 2018 он, түүвэр судалгаа

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ

МУ-д эх нярайн тусламж үзүүлж буй байгууллагадад агшингийн судалгааны загвараар 2016 оны ДЭМБ-ын зөвлөмж болгосон “Эрүүл мэндийн байгууллагын эх болон нярайн тусламжийн чанарыг сайжруулах удирдамж”-ийн дагуу гүйцэтгэсэн.

3.1. Судалгааны загвар

Монгол Улсын жирэмсний хяналтын чанарыг үнэлэхдээ 2023 оны 2-оос 4-р улирлын хооронд аналитик судалгааны агшингийн загвараар хийж гүйцэтгэлээ. Мэдээ мэдээлэл материалыг чанарын болон тоон судалгааны аргаар цуглуулсан.

3.2. Судалгааны түүвэр

Судалгааг үндэсний хэмжээнд ЭХЭМҮТ, ЭНЭҮТ II, амаржих газрууд, аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төв гэх нийт 65 ҮҮН-ээс мэдээлэл цуглуулж жирэмсний хяналтын чанарыг судалж, 2019, 2021 онд жирэмсний хяналтад байсан, амаржсан 1220 эмэгтэйг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгон авч, тэдгээрийн жирэмсний хяналтын явцыг үнэлсэн.

Судалгааны түүвэрлэлт: Судалгааны түүвэрлэлт: Судалгааны эх олонлог нь Монгол улсад жирэмсний тусламж үйлчилгээ үзүүлж буй үйлчилгээ үзүүлэгч нэгж (ҮҮН) болон 2020-2021 онд амаржсан эхчүүд болно. Судалгаанд шаардлагатай түүврийн хэмжээг хувь тооцох таамаглалын хүрээнд дараах томьёогоор тооцсон. Тооцоололд итгэх интервалыг 95%, алдааны хязгаарыг 5%, таамаглалын суурь түвшинг 0.5 байхаар тооцсон. Монгол улсын хэмжээнд 2021 онд 71659 эмэгтэй амаржсан байна. ҮСХ-ны тайлан мэдээгээр манай улсад 2021 оны байдлаар 71,659 эх амаржсан байна(Хүснэгт 3).

$$n = \frac{[DEFF * Np(1-p)]}{\left[\frac{d^2}{Z^2_{\frac{1-a}{2}}} * (N-1) + p * (1-p)\right]}$$

Үүнд:

N – Эх олонлог, Монгол улсын хэмжээнд амажрсан эхийн тоо 71659

$Z^2_{\frac{1-a}{2}}$ – Судалгааны таамаглалын итгэх интервал, 95.0%

d – Алдааны хязгаар, 0.05

p – Таамаглалын суурь түвшин, 0.5

Deff- Загварын нөлөөлөл, 4.0

Хүснэгт 2. ҮҮН-ийн түүврийн хуваарилалт

Д/д	Засаг захиргааны нэгж	ҮҮН-ийн шатлал		Нийт
		Лавлагаа шатлал	Анхан шат	
Улаанбаатар				
1	Багануур	1	1	**2**
2	Баянзүрх	1	1	**2**
3	Хан-Уул	1	1	**2**
Нийт		**3**	**3**	**6**
Баруун бүс				
4	Баян-Өлгий	1	1	**2**
Хангайн бүс				
5	Сэлэнгэ	1	1	**2**
Төвийн бүс				
	Төв	1	1	**2**
Зүүн бүс				
6	Сүхбаатар	1	1	**2**
7	Дорнод	1	1	**2**

Хүснэгт 1. Түүврийн хэмжээ

Эх олонлог	Итгэх түвшин	Итгэх засвар	Түүврийн хэмжээ
71.659	95%	±4.17	1220

Тайлбар: Итгэх түвшин 95% гэдэг нь судалгааны үр дүнд 95% итгэж болно. Итгэх завсар ±4.17 гэдэг нь судалгааны тоон үзүүлэлтүүд хамгийн ихдээ эсвэл хамгийн багадаа 4.17 нэгжээр хэлбэлзэнэ гэсэн утгыг илэрхийлнэ.

Улсын хэмжээнд жирэмсний хяналтын тогтолцооны нөхцөл байдлыг судлах, судалгааны ажлыг илүү бодитой гаргах хүрээнд нийслэл хот болон 13 аймгийг хамруулаа. Энд Улаанбаатар хотын төрөлтийн хэмжээ орон нутагтай харьцуулахад дийлэнх хувийг нь дангаараа бүрдүүлдэг учир 30 хувийг Улаанбаатар хотын дүүргүүдээс тэнцүү байхаар түүвэрлэн оруулаа (хүснэгт 3).

Хүснэгт 4. Түүврийн хуваарилалт

№	Нийслэл/Орон нутаг	Амаржсан эх
	Улаанбаатар хот	354
Баруун бүс		
	Баян-Өлгий	117
	Увс	29
	Ховд	40
Хангайн бүс		
	Архангай	34
	Баянхонгор	129
	Завхан	41
Төвийн бүс		
	Орхон	105
	Төв	84
	Булган	76
	Сэлэнгэ	76
	Дорноговь	53
Зүүн бүс		
	Сүхбаатар	46
	Дорнод	36
Нийт		**1220**

Ганцаарчилсан ярилцлагыг 40 хүнтэй хийхээр төлөвлөсөн бөгөөд Улаанбаатар хотоос 15, орон нутгийн бүсийн төлөөлөл болгон тус бүр 5 ярилцлага хийхээр хуваариллаа.

Хүснэгт 5. Ганцаарчилсан ярилцлага

№	Нийслэл/Орон нутаг	Оролцогчийн тоо
1	Улаанбаатар хот	15
2	Төвийн бүс	5
3	Баруун бүс	5
4	Зүүн бүс	5
5	Хангайн бүс	5
6	Баруун бүс	5
	Нийт	**40**

Баруун бүсийн Баян-Өлгий, Хангайн бүсийн Архангай, Баянхонгор, Төвийн бүсийн Төв, Сэлэнгэ, Зүүн бүсийн Сүхбаатар аймгийг сонгож, аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлэг, аймгийн төвд ойр байрлалтай 1, алслагдсан 1 сумыг тус тус хамруулсан.

1. **Эмнэлгүүдийн түүвэрлэлт:** Судалгаанд хамрагдсан 13 аймаг, 6 дүүргийн нэгдсэн эмнэлгийн ЭМТ, ӨЭМТ, СЭМТ-д ЭМС-ын 2020 оны А/318 тоот тушаалаар батлагдсан “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний журам”-ын хэрэгжилтийг үнэлсэн. Судалгаанд

хамрагдах аймаг, хотын эмнэлгүүдийг сонгохдоо жирэмсний хяналтын үр дүнг илтгэхүйц эрүүл мэндийн үзүүлэлт болох амьгүй төрөлтийн тоо, түвшин, эхийн ноцтой хүндрэл, эндэгдлийн тоо, харьцааг үндэслэн Баруун бүсийн Баян-Өлгий, Хангайн бүсийн Баянхонгор, Төвийн бүсийн Төв, Булган, Орхон, Сэлэнгэ, Зүүн бүсийн Дорнод, Сүхбаатар аймгийг сонгож, аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлэг, аймгийн төвд ойр байрлалтай 1, алслагдсан 1 сумыг тус тус хамруулсан.

2. **Эмнэлгүүдийн эмч, ажилчдын түүвэрлэлт:** Судалгаанд хамрагдсан аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, ЭМТ, ӨЭМТ, СЭМТ-ийн жирэмсний хяналтын тусламж үйлчилгээний чанарт үнэлгээ хийсэн. ЭМБ-ын хүний нөөцийн байдлыг эх барих эмэгтэйчүүдийн эмч, эх баригчийн батлагдсан орон тоо, одоо ажиллаж буй эмч, эх баригчийн тоо, ажлын туршлага, мэргэжлийн ур чадвар,ажлын байрны болон зайн сургалтын хамрагдалтын байдал (хэрэгсэл 3)-ыг үнэлсэн. Нийслэлийн 6 дүүргийн ЭМТ, ӨЭМТ, сонгогдсон 13 аймгийн СЭМТ-ийн эмч ажилчдаас удирдах ажилтан-1, эх барих эмэгтэйчүүдийн эмч/их эмч-1, эх баригч-1, нийт 3 хүнийг санамсаргүйгээр сонгон, судалгаанд хамруулна, нийт түүврийн хэмжээ 60. Нийслэлийн 3 амаржих газар, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ, 6 аймгийн нэгдсэн эмнэлгийн удирдах ажилтан-1, эх барих эмэгтэйчүүдийн эмч-1, нярайн эмч-1, эх баригч-1, нийт 5 хүнийг санамсаргүйгээр сонгон, судалгаанд хамруулсан. Сонгогдсон эмнэлгүүдийн **эмч, ажилчдаас судалгаанд 128** хүнийг оролцуулсан.
3. **Үйлчлүүлэгчдийн түүвэрлэлт:** Сонгогдсон эмнэлгүүдийн төлөөллийг ***асуумж, ганцаарчилсан ярилцлагад*** хамруулж, жирэмсний хяналтын тусламж үйлчилгээний өнөөгийн байдал”-д үнэлгээ өгсөн.
    - ✓ ***Асуумж*** (жирэмсэн, төрсний дараах эхчүүд): Нийслэлийн 6 дүүргийн ЭМТ, ӨЭМТ, сонгогдсон 13 аймгийн СЭМТ-ийн үйлчлүүлэгчдийг, Нийслэлийн 3 амаржих газар, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ, 13 аймгийн нэгдсэн эмнэлгийн үйлчлүүлэгчийг санамсаргүйгээр сонгон, судалгаанд хамруулаа.
    - ✓ ***Ганцаарчилсан ярилцлагад*** (Сүүлийн 1 жилд амаржсан эхчүүд): Сонгогдсон ЭМТ, ӨЭМТ, СЭМТ-ийн үйлчлүүлэгчээс, Амаржих газар, лавлагаа төв, аймгийн нэгдсэн эмнэлгийн үйлчлүүлэгчийг санамсаргүйгээр сонгон, судалгаанд хамруулаа.

3.3. Судалгааны хэрэглэгдэхүүн

Жирэмсний хяналтын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэхдээ тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан хэрэглэсэн.

Тоон судалгааны арга: Тусгайлан боловсруулсан асуумжын хуудсыг ашиглан эмнэлгийн ажилчид болон амаржсан эхчүүдээс авсан.

1. Пасспортын хэсэг
2. Жирэмсний хяналтын тусламж, хүртээмжийн асуумж
3. Жирэмсний явцыг үнэлэх асуумж
4. Төрөлтийн талаархи асуумж
5. Төрсний дараах үеийг асуумж
6. Эхийн ноцтой хүндрэл, эндэгдлийг бүртгэх асуумж

Чанарын судалгааны арга: Ганцаарчилсан ярилцлагын удирдамжийн дагуу тусгайлан сургагдсан модераторууд ярилцлагыг авсан.

Хяналтын хуудас бөглөх, үйлчлүүлэгч ба үйлчилгээ үзүүлэгч нартай ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх, эмч, мэргэжилтний мэдлэг шалгах асуумж, үнэлгээний хуудсыг боловсруулан ашигласан.

Хүснэгт 6. Судалгааны хэрэглэгдэхүүний жагсаалт

д/д	Судалгааны хэрэглэгдэхүүн
1	Үндэсний түвшний мэдээлэл
2	Байгууллагын үнэлгээ
3	ЭМБ-уудын эрүүл мэндийн бүртгэл, мэдээлэл
4	ЭМБ-уудын хүний нөөцийн мэдээлэл
5	ЭМБ-уудын тусламж үйлчилгээний нэгж хэсгүүдийн бэлэн байдал
6	ЭМБ-уудын эмч, эх баригч нарын мэдлэг, ур чадвар, ажлын туршлага
7	Жирэмсний хяналтын удирдамжийн хэрэгжилт
8	Төрсний дараах үеийн тусламж
9	ЭМБ-ын удирдлагуудтай хийх ярилцлага
10	Эмч, эх баригч нартай хийх ярилцлага
11	Үйлчлүүлэгчтэй (жирэмсэн, амаржсан эх) хийх ярилцлага

3.4. Судалгааны зохион байгуулалт

1-р шат: Үнэлгээг гүйцэтгэх багийн гишүүдэд судалгааны зорилго, зорилт, материал арга зүй, боловсруулалт, судалгааны хэрэгслүүдийг зааврын дагуу хийж гүйцэтгэх, өөрөөр хэлбэл эмнэлгүүдийн эмч, ажилчид, үйлчлүүлэгчдээс асуумж, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагыг авах аргачлал, үнэлгээний явцад тулгарч болзошгүй алдаа дутагдлын талаар тайлбар өгөх зорилго бүхий чиглүүлэх сургалтыг хийсэн.

2-р шат: Үндэсний мэдээллийг ХӨСҮТ, ҮСХ, ЭМХТ, ЭХЭМҮТ-ТСА-аас цуглуулан авна. Мөн сонгогдсон байгууллагуудаас ЭМС-ын А/611 маягтын дагуух мэдээллийг цуглуулан авсан.

3-р шат: Судалгааг сонгогдсон эмнэлгүүдэд хийж гүйцэтгэхэд ЭХЭМҮТ-ийн эмч, судлаачдаас бүрдсэн багуудыг ажиллуулсан. Багийн ахлагч нар багийн гишүүдийн цуглуулж буй мэдээллийн бүрэн гүйцэд байдал, оновчтой, харилцан хамааралтай эсэхэд хяналт тавин, хот суурин болон хөдөө орон нутагт өдөр тутмын удирдлагаар хангах үүрэгтэй оролцсон.

Үнэлгээний явцад судалгаанд хамрагдах эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч болон үйлчлүүлэгч нарт өөрсдийн судалгааны зорилгыг тайлбарлаж, аман зөвшөөрлийг авч, судалгаанд хамруулсан.


3.5. Судалгааны статистик боловсруулалт

Асуумж судалгааны өгөгдлийг “IBM SPSS 26.0” програмыг ашиглан хувьсуурүүдыг тоо хувиар, үргэлжилсэн хувьсуурийг тархалтыг үнэлж дундаж стандарт хазайлтаар илэрхийлсэн. Бүлэг хоорондын ялгааг хи квадрат тест, фишерийн тест ашиглан үнэлэв. P утга 0.05-аас бага тохиолдолд статистик үнэн магадтай гэж үзсэн. Эхийн ноцтой хүндрэл, эндэгдлийн харьцааг жирэмсний хяналтын чанар, хүртээмж хоорондын хамаарлыг регрессийн шинжилгээгээр үнэлсэн.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН


4.1. Жирэмсний хяналтын чанарын судалгаанд хамрагдсан ҮҮН-ийн ерөнхий мэдээлэл

Судалгаанд нийт 8 аймаг, Улаанбаатар хотын 3 дүүргийн анхан ба лавлагаа шатлалын 22 эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч нэгжийг хамруулаа (Зураг 1).




Зураг 1. Судалгаанд хамруулсан аймаг, хот

Судалгаанд хамрагдсан ҮЭН-ийн харьяа хүн амд эзлэх нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь ялгаатай байна. Тодруулбал, нийт харьяа хүн амын 20-35%-ийг нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд дунджаар 25%-ийг эзэлдэг байна. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн ҮЭН-ийн харьяа хүн амд эзлэх хувь нь АНЭ/БОЭТ-д өсөлт, бууралт ажиглагдаагүй бөгөөд сумын эрүүл мэндийн төвийн харьяа буюу хөдөө орон нутагт нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь өссөн үзүүлэлт ажиглагдлаа.



Зураг 2. YYH-ийн харьяа нийт хүн амд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь

Нийт жирэмсний хяналтад хамрагдсан эмэгтэйчүүдийн дунд өндөр эрсдэлтэй жирэмсний эзлэх хувь өсөх хандлагатай байгаа бөгөөд ӨЭМТ-д хяналтад орж буй жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд өндөр эрсдэлтэй жирэмсний эзлэх хувь 2019 оноос 2022 онд 13.4% өссөн үзүүлэлттэй байна. Мөн 2022 онд жирэмсний хяналтад орсон эмэгтэйчүүдийн дунд өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйн эзлэх хувь ӨЭМТ-үүдэд өсч, ДНЭ-үүдэд буурсан үзүүлэлт ажиглагдлаа. Түүнчлэн анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч нэгж болох СЭМТ-д өндөр эрсдэлтэй жирэмсний хяналтын хувь өссөн байна.




Зураг 3. Нийт жирэмсний хяналтад хамрагдсан эмэгтэйн дунд өндөр эрсдэлтэй жирэмсний эзлэх хувь, YYH-ийн шатлалаар

4.2. YYH-ийн жирэмсний хяналтын чанарыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шатлалаар харьцуулсан үр дүн


YYH-ийн буюу тухайн аймаг, дүүргийн жирэмсний хяналтын чанарыг үнэлэхдээ эхийн эндэгдэл гарсан байдлаар тооцсон. Эхийн эндэгдэл бүртгэгдсэн тохиолдолд жирэмсний хяналтын чанар хангалтгүй гэж тооцсон. ОУ-ын хэвлэлийн тоймоос харахад жирэмсний хяналтын чанарыг эхийн эндэгдэл болон үйлчилгээг стандартын дагуу үзүүлж буй байдлыг талбарт үнэлж тодорхойлж байгаа бөгөөд 22 YYH-д тус бүрчлэн байрлан ажиллаж, явцыг хянаж үнэлэх нь ихээхэн цаг, хугацаа шаардах бөгөөд мэдээлэл цуглуулалтын алдаа гарах магадлал өндөртэй арга болж байна. Тиймээс бид жирэмсний хяналтын чанарыг үнэлэхдээ шууд хэмжилтийн арга буй тухайн YYH-д эхийн эндэгдэл гарсан эсэхээр дүгнэсэн.

Зураг 4-т судалгаанд хамрагдсан YYH-ээс жирэмсний хяналтын чанар хангалттай буюу эхийн эндэгдэл бүртгэгдээгүй YYH эзлэх хувийг оноор харьцуулан илэрхийллээ. Жирэмсний хяналтын чанар 2019, 2020 онд тогтвортой 63.9%-д хангалттай байсан бөгөөд 2021 онд эрс буурч, 2022-2023 оны эхний хагасын дүнгээр өссөн үзүүлэлттэй байна. 2021 онд КОВИД-19 тархалттай холбоотой эхийн эндэгдэлд нэмэгдсэн нь жирэмсний хяналтын чанарт нөлөөлсөн байж болох юм.




Зураг 4. Жирэмсний хяналтын чанар хангалттай YYH-ийн эзлэх хувь, оноор харьцуулсан үр дүн; *Энэхүү зураг жирэмсний хяналтын чанар хангалттай байгаа YYH-ийн эзлэх хувийг илэрхийлсэн. Жирэмсний хяналтын чанар хангалттай гэдэг нь эхийн эндэгдэлгүй YYH юм.*

Нэг эмчид ногдох жирэмсэн эмэгтэйн тоо нь ДНЭ-үүдэд 2019-оноос 2022 онд өссөн байгаа нь ДНЭ-т ажиллаж буй ЭБЭЭ-ийн эмчийн тоотой хамааралтай байж болох юм.



	2019	2020	2021	2022
Дүүрэг	264	261	331	482
ӨЭМТ	75	64	54	58
АНЭ/БОЭТ	132	131	132	125
СЭМТ	98	94	87	90

Зураг 5. Нэг эмчид оногдох жирэмсэн эмэгтэйн тоо, YYH-ийн шатлалаар харьцуулсан үр дүн



Зураг 6. Эх барих эмэгтэйчүүдийн тоо, оноор харьцуулсан үр дүн; a. ӨЭМТ, b. СЭМТ, c. ДНЭ, d.АНЭ

Жирэмсний хяналтад шаардлагатай, лабораторийн шинжилгээний багаж, тоног төхөөрөмжийн хүртээмж ДНЭ, АНЭ/БОЭТ-д бүрэн хангалттай байхад, ӨЭМТ, СЭМТ-үүдэд бактериологийн шинжилгээ хийгддэггүй байна.

Хүснэгт 7. YYH-ийн жирэмсний хяналтад шаардлагатай, лабораторийн шинжилгээний багаж, тоног төхөөрөмжийн хүртээмжийн байдал

	YYH шатлал			
	Дүүрэг	ӨЭМТ	АНЭ/БОЭТ	СЭМТ
ДОХ-ын вирус илрүүлэх боломж	100.0%	57.1%	100.0%	100.0%
Серологийн шинжилгээ хийх боломж	100.0%	28.6%	100.0%	0.0%
Вирусын шинжилгээ хийх боломж	100.0%	42.9%	100.0%	66.7%
Цусны бүлэгнэлтийн шинжилгээ хийх боломж	100.0%	0.0%	100.0%	100.0%
Биохимийн шинжилгээ хийх боломж	100.0%	50.0%	100.0%	66.7%
Цусны дэлгэрэнгүй шинжилгээ хийх боломж	100.0%	50.0%	100.0%	66.7%
Шээсний шинжилгээ хийх боломж	100.0%	57.1%	100.0%	100.0%
Бактериологи лаборатори	100.0%	0.0%	100.0%	0.0%
Бактериологийн лаборант байгаа	100.0%	0.0%	100.0%	0.0%

Судалгаанд хамрагдсан ӨЭМТ-ийн 16.7%-д жирэмсний хяналтанд шаардлагатай шээсний ариун чанар авах сав, 42.9%-д умайн хүзүүний бактериологи авах савх байдаг бол СЭМТ-ийн 66.7%-д умайн хүзүүний бактериологи авах савх байдаг (Хүснэгт 8).

Түүнчлэн жирэмсний хяналтанд шаардлагатай рентген аппарат, рентген техникч ӨЭМТ-үүдэд огт байдаггүй бол СЭМТ-ийн 50.0%-д рентген аппарат байдаг ч рентген техникч байдаггүй. ӨЭМТ-ийн 33.3%-д цусны бүлэг, резус бүлэг тодорхойлогч шинжилгээний хэрэгсэл байдаг гэж хариулжээ (Хүснэгт 9).


Хүснэгт 8. YYH-ийн жирэмсний хяналтад шаардлагатай, лабораторийн шинжилгээний багаж, тоног төхөөрөмжийн хүртээмжийн байдал

	УҮН шатлал							
	Дүүрэг		ӨЭМТ		АНЭ/БОЭТ		СЭМТ	
Нэг удаагийн толь хангагдсан	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%
Шээсний ариун чанар авах сав байгаа	✓	100.0%	✗	16.7%	✓	100.0%	!	66.7%
Умайн хүзүүний бактериологи авах савх байгаа	✓	100.0%	✗	42.9%	✓	100.0%	✓	100.0%
Биеийн жин үзэгч байгаа эсэх	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%
Хэвлийн тойрог, умайн ёроолын өндөр үзэх туурзан метр	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%
Тазометр байгаа эсэх	✓	100.0%	✓	85.7%	✓	100.0%	✓	100.0%
Артерийн даралт үзэх аппарат байгаа эсэх	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%
Пульсоксиметр байгаа эсэх	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%
Цаг байгаа эсэх	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%
Халуун хэмжигч байгаа эсэх	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%
Чагнуур байгаа эсэх	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%

Хүснэгт 9. УҮН-ийн жирэмсний хяналтад шаардлагатай, лабораторийн шинжилгээний багаж, тоног төхөөрөмжийн хүртээмжийн байдал

	УҮН шатлал							
	Дүүрэг		ӨЭМТ		АНЭ/БОЭТ		СЭМТ	
Цусны бүлэг тодорхойлогч байгаа эсэх	✓	100.0%	✗	33.3%	✓	100.0%	✓	100.0%
Резус бүлэг тодорхойлогч байгаа эсэх	✓	100.0%	✗	33.3%	✓	100.0%	✓	100.0%
Тэмбүүгийн хурдавчилсан сорил байгаа эсэх	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%
ХДХВ-ийн хурдавчилсан сорил	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%
Шээсний хурдавчилсан сорил	✓	100.0%	✗	42.9%	✓	85.7%	✓	100.0%
Элэгний В,С вирус илрүүлэх хурдавчилсан сорил	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%	✓	100.0%
Рентген аппарат байгаа	✓	100.0%	✗	0.0%	✓	100.0%	!	50.0%
Рентген техникч байгаа	✓	100.0%	✗	0.0%	✓	100.0%	✗	0.0%

Жирэмснийн хяналтын чанар хангалтгүй бүс нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын оношилгоо, шинжилгээний бэлэн байдал хяналтын чанар хангалттай бүс нутгийн эрүүл мэндийн байгууллагуудтай харьцуулахад тааруу буюу рентген техникч (28.6%), шээсний ариун чанар авах сав (28.6%) хангагдсан байдал 30-аас доош хувийг эзэлж байна.



Зураг 7. Эрүүл мэндийн байгууллагуудын оношилгоо, шинжилгээний бэлэн байдал, жирэмсний хяналтын чанараар

4.3. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүс нутгийн ҮҮН-ийн жирэмсний хяналтын чанарыг үнэлсэн үр дүн

Судалгаанд нийт сүүлийн 3 жилийн хугацаанд жирэмсний хяналтад хамрагдсан 1220 эмэгтэйг хамруулсан. Судалгаанд хамрагдсан эхчүүдийн 58.0% нь жирэмсний хяналтад 6 ба түүнээс бага удаа хамрагджээ. Жирэмсний хяналтын эхний үзлэгт 27.7% нь сувилагчаас зөвлөгөө авсан. Нийт оролцогсдын 80.6% (n=980) нь 20 долоо хоногтой, 41.6% (n=498) нь 32 долоо хоногтойд эмэгтэйчүүдийн нарийн мэргэшлийн эмчийн зөвлөгөө авсан. Жирэмсний хяналтын эмч эхчүүдийн 19.6%-д фолийн хүчил, 22.7% төмрийн бэлдмэл зөвлөөгүй.

Хүснэгт 10. Судалгаанд оролцогсдын ерөнхий мэдээлэл

Үзүүлэлт		Жирэмсний хяналтын чанар			
		Хангалттай n(%)	**Хангалтгүй n(%)**	**Нийт n(%)**	**p-утга**
Жирэмсний хяналтын эмчид үзүүлсэн хугацаа (Дундаж ± стандарт хазайлт)		20.46±8.01	19.35±10.4	19.84 ± 9.45	
Жирэмсний эхний үзлэгийг хийсэн эмнэлгийн мэргэжилтэн	Сувилагч	96(17.9)	238(35.5)	334(27.7)	0.000
	Эх баригч	97(18.1)	65(9.7)	162(13.4)	
	Их эмч	202(37.8)	259(38.7)	461(38.3)	
	Эх барих эмэгтэйчүүдийн эмч	140(26.2)	108(16.1)	248(20.6)	
Жирэмсний хяналтанд орсон эмнэлэг	Өрх/сум	256(47.2)	454(67)	710(58.2)	0.000
	Аймаг/дүүрэг	276(50.9)	210(31)	486(39.8)	0.000
	Амаржих газар/ЭХЭМҮТ	14(2.6)	10(1.5)	28(2.3)	0.171
	Хувийн эмнэлэг	16(3)	12(1.8)	24(2)	0.166
	Хяналтанд ороогүй	0(0)	5(0.7)	5(0.4)	0.04
Жирэмсний хяналтанд хамрагдсан тоо	1-2 удаа	17(3.2)	89(13.5)	106(8.9)	0.000
	3-4 удаа	76(14.2)	130(19.7)	206(17.3)	
	5-6 удаа	170(31.8)	210(31.8)	380(31.8)	
	7-8 удаа	155(29)	160(24.2)	315(26.4)	
	8-аас дээш удаа	116(21.7)	71(10.8)	187(15.7)	
Эх барих эмэгтэйчүүдийн эмчийн зөвлөгөө авсан эсэх	20 долоо хоногтойд	420(77.5)	560(83.1)	980(80.6)	0.01
	32 долоо хоногтойд	181(34)	317(47.8)	498(41.6)	0.000
Нийт		**542(100.0)**	**678(100.0)**	**1220(100.0)**	


Жирэмсний хяналтын чанар хангалтгүй бүс нутагт 18-аас доош настай тулгар төрөгч, нэн ядуу болон хоол тэжээлийн дутагдалтай жирэмсэн эмэгтэйн эзлэх хувь өндөр байна.

Хүснэгт 11. Жирэмсний нийгэм биологийн хүчин зүйлс

Жирэмсний нийгэм биологийн хүчин зүйлс	Жирэмсний хяналтын чанар			
	Хангалттай n(%)	**Хангалтгүй n(%)**	**Нийт n(%)**	**p-утга**


18-с доош настай тулгар төрөгч	36(6.6)	61(9)	97(8)	0.127
30-аас дээш настай тулгар төрөгч	109(20.1)	119(17.6)	228(18.7)	0.255
35-аас дээш настай тулгар төрөгч	103(19)	132(19.5)	235(19.3)	0.838
5 ба түүнээс олон төрсөн	31(5.7)	27(4)	58(4.8)	0.154
Нэн ядуу жирэмсэн эмэгтэй	4(0.7)	15(2.2)	19(1.6)	**0.03**
Хоол тэжээлийн дутагдалтай	8(1.5)	55(8.1)	63(5.2)	**0.000**
Байнга тамхи, архи, мансууруулах бодис хэрэглэдэг	5(0.9)	11(1.6)	16(1.3)	0.286
Хүчирхийлэлд өртдөг	5(0.9)	7(1)	12(1)	0.841
Бусад	2(0.4)	3(0.4)	5(0.4)	0.842

Судалгаанд хамрагдсан нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 21.1% нь бөөр, шээсний замын замын эмгэгтэй, 15.6% нь цусны эмгэгтэй, 13.0% нь зүрх судасны эрхтэн тогтолцооны эмгэгтэй, 8.3% нь таргалалттай байсан.



Зураг 8. Жирэмсэн эмэгтэйчүүдийн эрхтэн тогтолцооны эмгэг

Жирэмсний хяналтын чанар хангалтгүй бүс нутагт жирэмсэн эмэгтэйчүүдэд бөөр шээсний замын эмгэг (25.6%), цусны эмгэг (12.9%), зүрх судасны эмгэг (12.2%) тэргүүлэх байр эзэлж байна.



Зураг 9. Жирэмсэн эмэгтэйчүүдийн эрхтэн тогтолцооны эмгэг, жирэмсний хяналтын чанараар, 2022 он

Жирэмсний хяналтын эмч судалгаанд хамрагдсан нийт эхчүүдийн 23.3% (n=284)-д жирэмсний аюултай шинж, 25.9%(n=314)-д жирэмсний хяналтын ач холбогдлын талаарх зөвлөгөө өгөөгүй байна. Жирэмсний хяналтын эмч эхчүүдийн 19.6%-д фолийн хүчил, 22.7% төмрийн бэлдмэл зөвлөөгүй.

Хүснэгт 12. Хяналтын эмч үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгсөн байдал, жирэмсний хяналтын чанараар, 2022 он

Жирэмсний хяналтын эмч зөвлөсөн эсэх	**Жирэмсний хяналтын чанар**		**Нийт n(%)**	**p-утга**
	Хангалттай n(%)	**Хангалтгүй n(%)**		
Фолийн хүчил уух талаар	414(77.4)	560(82.7)	974(80.4)	**0.02**
Төмрийн бэлдмэл уух талаар	402(74.2)	541(79.8)	943(77.3)	**0.02**
Жирэмсний аюултай шинжүүдийн талаар	387(71.4)	549(81)	936(76.7)	**0.000**
Жирэмсний хяналтын ач холбогдлын талаар	383(71.3)	517(76.4)	900(74.1)	0.46

Амны хөндийн эрүүл ахуйг сахих талаар	318(59.6)	420(61.9)	738(60.9)	0.396
Бэлгийн замаар дамжих халдварын талаар	362(67.4)	484(71.5)	846(69.7)	0.124
Зулбалт, дутуу төрөлтөөс сэргийлэх	378(70.4)	472(69.6)	850(70)	0.77
Цус багадалтын талаар	379(70.8)	503(74.3)	882(72.8)	0.17
Төрөлтийн тухай, төрлөг эхлэх шинж	356(66.4)	493(72.8)	849(70)	**0.016**
Жирэмсний хожуу хордлогын талаар	356(66.3)	474(70.1)	830(68.4)	0.155
Ургийн хөдөлгөөнийг хянах тухай	386(72)	513(75.8)	899(74.1)	0.138
Пренатал илрүүлэг оношилгооны талаар	298(56.1)	490(72.4)	788(65.2)	**0.000**
Төрсний дараах үеийн талаар	340(63.6)	475(70.4)	815(67.4)	**0.12**


Жирэмсний үед хүндрэл үүсэх байдал буюу жирэмсний хяналтын чанар сул байхад зүрх судасны эмгэг, цусны эмгэг, бөөр шээсний замын эмгэг, таргалалт зэрэг нөлөөлж байна.

Хүснэгт 13. Эмэгтэйн эрхтэн тогтолцооны эмгэг ба жирэмсний хүндрэл

Эрхтэн тогтолцооны эмгэг	**Жирэмсний хүндрэл**				**p-утга**
	Илрээгүй		**Илэрсэн**		
	тоо	**хувь**	**тоо**	**хувь**	
Зүрх судасны эмгэг	43	7.5%	114	17.8%	**0.000**
Амьсгалын замын эмгэг	12	2.1%	20	3.1%	0.259
Хоол боловсруулах замын эмгэг	30	5.2%	34	5.3%	0.942
Бөөр шээсний замын эмгэг	91	15.9%	164	25.7%	**0.000**
Дотоод шүүрлийн булчирхайн эмгэг	18	3.1%	26	4.1%	0.389
Цусны эмгэг	66	11.5%	123	19.3%	**0.000**
Хөх/эмэгтэйчүүдийн эмгэг	8	1.4%	9	1.4%	0.986
Халдварт өвчин	13	2.3%	20	3.1%	0.358
Нүдний эмгэг	33	5.8%	53	8.3%	0.086
Сэтгэцийн эмгэг	1	0.2%	5	0.8%	0.132
Мэдрэлийн эмгэг	7	1.2%	8	1.3%	0.962
Холбогч эдийн өвчин	1	0.2%	4	0.6%	0.221
Аутоиммунийн өвчин	2	0.3%	4	0.6%	0.493
Хорт хавдар	0	0.0%	4	0.6%	0.058

Эрхтэн шилжүүлсэн суулгах мэс засал хийлгэсэн	1	0.2%	3	0.5%	0.371
Резус сөрөг бүлгийн цустай	4	0.7%	5	0.8%	0.865
Таргалалт	30	5.2%	70	11.0%	**0.000**
Бусад эмгэг	42	7.3%	55	8.6%	0.408

Судалгаанд оролцогчдын жирэмсний эрсдэлийг тодорхойлж, жирэмсний хүндрэлд хэрхэн нөлөөтэйг үнэлхэд “өмнөх жирэмслэлт, төрөлтийн үед цус алдаж байсан, манас таталтын урьдал, үжлээр хүндэрч байсан, ураг нярай эндэж байсан өгүүлэмжтэй, байнга архи тамхи хэрэглэдэг, хоол тэжээлийн дутагдалтай, нэн ядуу, 30-с дээш болон 18-с доош насны тулгар төрөгч” нарт хүндрэл тохиолдох нь статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаатай байлаа.



Зураг 10. Жирэмсний хүндрэлд нөлөөлж буй жирэмсэн эхийн нийгэм биологийн хүчин зүйлс ба өмнөх жирэмслэлтийн ужиг дурдатгалууд, *p<0.05, ***p<0.0001

Жирэмсний хяналтын чанар хангалтгүй байхад жирэмсэн эмэгтэй нэн ядуу болон хоол тэжээлийн дутагдалтай байх, жирэмсний хяналтанд үзүүлсэн тоо болон зарим эрхтэн тогтолцооны хавсарсан эмгэг нөлөөлж байна.

Хүснэгт 14. Жирэмсний хяналтын чанар хангалтгүй байхад нөлөөлөх хүчин зүйлсийн логистик регрессийн үнэлгээ

	B	S.E.	Sig.	OR	CI 95%	
					Бага	Их
Жирэмсний нийгэм биологийн хүчин зүйлс						
Нэн ядуу жирэмсэн эмэгтэй	1.451	0.689	0.035	4.267	1.106	16.469
Хоол тэжээлийн дутагдалтай	1.917	0.412	0.000	6.800	3.033	15.248
5 ба түүнээс олон төрсөн	-0.700	0.304	0.021	0.497	0.274	0.902
Жирэмсний хяналтанд үзүүлсэн тоо						
>8 удаа				1		
1-2 удаа	2.146	0.305	0.000	8.553	4.709	15.538
3-4 удаа	1.028	0.209	0.000	2.795	1.856	4.207
5-6 удаа	0.702	0.183	0.000	2.018	1.411	2.887
7-8 удаа	0.523	0.188	0.005	1.687	1.166	2.439
Эрхтэн тогтолцооны эмгэг						
Бөөр шээсны замын эмгэг	0.691	0.155	0.000	1.995	1.472	2.703
Цусны өвчин	-0.506	0.165	0.002	0.603	0.436	0.834
Таргалалт	-0.784	0.222	0.000	0.456	0.295	0.706
Мэдрэлийн эмгэг	1.732	0.862	0.044	5.651	1.044	30.594
Хяналтын эмч зөвлөмж өгсөн						
Зулбалт, дутуу төрөлтөөс сэргийлэх	-0.845	0.225	0.000	0.430	0.276	0.668
Жирэмсний аюултай шинж	0.916	0.208	0.000	2.500	1.663	3.758
Төмрийн бэлдмэл уух	0.982	0.165	0.000	2.669	1.931	3.691

4.4. Жирэмсний хяналтын чанарт ҮҮН-ийн эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний үзүүлэх нөлөөллийг тооцсон үр дүн


Судалгаанд анхан ба лавлагаа шатлалын эмнэлэгт жирэмсний хяналтыг тусламж үйлчилгээ үзүүлж буй эмч, эмнэлэгийн мэргэжилтнүүдийг хамруууллаа. Нийт хамрагдагсдын 15.2% нь эх барих эмэгтэйчүүд, 53.4% нь ерөнхий мэргэжлийн хүний их эмч байв.

Хүснэгт 15. Жирэмсний чанарын хяналтын судалгаанд хамрагдсан эмч, эмнэлэгийн мэргэжилтэнүүдийн ерөнхий мэдээлэл

	Тоо	Хувь
Ажилласан жил, дундаж±cх	10±3.7	
Албан тушаал		
Сувилагч	11	6.2%
Эх баригч, бага эмч	45	25.3%
Их эмч	95	53.4%
Эх барих эмэгтэйчүүдийн эмч	27	15.2%
Нийт	117	100.0%


4.4.1. Эмч, эмнэлэгийн мэргэжилтнүүдийн жирэмсний хяналтын талаарх мэдлэг ба жирэмсний хяналтын чанар хоорондын хамаарлыг судалсан үр дүн

Жирэмсний хяналтын талаарх мэдлэгийг жирэмсний хяналтын А318-р тушаал, олон улсын хэвлэлийн тоймд үндэслэн боловсруулсан 10 асуулт бүхий асуулгын хуудсаар үнэлсэн. Асуулт тус бүрийн зөв хариултыг 1 оноогоор тооцож, 7 ба түүнээс дээш асуултад зөв хариулсан тохиолдолд мэдлэг хангалттай гэж үнэллээ. Нийт судалгаанд хамрагдагсдын 61.9% жирэмсний хяналтын талаарх мэдлэг хангалттай буюу сайн байв. Зурагт жирэмсний хяналтын талаарх мэдлэгийг эмч, эмнэлэгийн мэргэжилтнээр харьцуулахад статистик ач холбогдол бүхий ялгаатай байв (p=0.023). Жирэмсний хяналтын талаарх мэдлэг эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын 92.6%, хүний их эмч нарын 62.1%, эх баригч нарын 51.1%, сувилагч нарын 27.3%-д мэдлэг хангалттай сайн байна.




Зураг. 11 Эмч, эмнэлэгийн мэргэжилтнүүдийн мэдлэгийн түвшинг харьцуулсан нь


Жирэмсний хяналтын чанарт тусламж үйлчилгээ үзүүлж буй багийн мэдлэг нөлөөлдөг байна. Энэхүү судалгааны дүнгээр жирэмсний хяналтын чанар хангалттай сайн, эхийн эндэгдэлгүй байгаа бүс нутгийн ҮЭН-ийн эмч, эмнэлэгийн мэргэжилтнүүдийн жирэмсний хяналтын талаарх мэдлэг 71.0% сайн байлаа.




Зураг 12.




Зураг 13.



Зураг 14




Зураг 15




Зураг 16.

Жирэмсэн үед хийгдэх шаардлагатай үтрээ, умайн хүзүүний наацын шинжилгээ хийгдэхгүй байх, сэжигтэй сүрьеэгийн тохиолдлыг нарийн мэргэжлийн эмчид илгээхгүй байх нь жирэмсний хяналтын чанарт нөлөөлж байна.




Зураг 17. Жирэмсэн үед хийгдэх шинжилгээ, сүрьеэгийн илрүүлгийн байдал

Жирэмсний эхний болон хоёр дах гурван сарын пренатал илрүүлэг, 24 ба 28 долоо хоногтойд жирэмсний явц, ургийн өсөлтийн хяналт нь жирэмсний чанар хангалтгүй байхад нөлөөлж байна.



Зураг 18. Жирэмсний эрт илрүүлэг болон жирэмсний явц, ургийн өсөлтийн хяналт, жирэмсний хяналтын чанараар

